

## **«БНМАУ, БНХАУ-ЫН ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСАГ БА СОЁЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР» БА МОНГОЛ, ХЯТАДЫН ХУДАЛДАА-ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА (1950-ИАД ОН)<sup>1</sup>**

*Намжилчойжилын Алтантөгс  
МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, доктор Ph.D  
Email: altantugs@num.edu.mn*

### **Оршил**

БНМАУ, БНХАУ-ын хооронд 1949 онд дипломат харилцаа тогтоож, 1950 онд харилцан элчин сайд суулгаж, сайн хөршийн найрамдалт харилцаа хөгжүүлж эхэлсэн билээ. 1930 оноос хойш зөвхөн ЗХУ-тай социалист худалдаа хийсээр хорин жилийг өнгөрөөсөн Монгол улсын хувьд шинэ байгуулагдсан Хятадтай худалдааг нээн явуулж, адуу ба цай, дүнсэн тамхи харилцан худалдаалах болсон нь эдийн засгийн чухал ач холбогдолтой байв. Гэвч хоёр улсын худалдааны нийт хэмжээ 1949-1952 онд тухайн үеийн ханшаар 6 сая рублиэс хэтэрсэнгүй бөгөөд 1953 оноос л өсөж эхэлсэн байна. Энэ хугацаанд Зөвлөлт-Хятадын худалдааны эргэлт 308 сая рублиэс 871 сая рубль болж, 2.5 дахин нэмэгджээ.

БНМАУ, БНХАУ-ын хооронд 1952 онд Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан бөгөөд энэ бол тус хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан анхны хэлэлцээр юм. Тус хэлэлцээр 1960 онд Найрамдал, харилцан туслалцах гэрээ байгуулагдах хүртэл найман жилийн хугацаанд хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засаг, соёлын харилцааг зохицуулах гол баримт бичиг байв.

Монгол, Хятадын харилцааны түүхийн голлох судалгааны бүтээлүүд тус хэлэлцээрийн талаар тусгайлан анхаарч, удаа дараа судлан бичиж ирсэн билээ. Энэхүү илтгэлийг зохиогчийн «Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх» номын судалгааны үр дүн болон тус сэдвээр урьд өмнө гарсан судалгааны бүтээл, өгүүллүүдэд тулгуурлан бичив. Илтгэлээр 1952 оны БНМАУ-БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрээс тус хоёр улсын эдийн засгийн харилцаанд үүсгэсэн үр нөлөөг илүү тодруулан гаргахыг хичээв. Тус илтгэл 1960 оноос өмнөх цаг хугацааг хамрах бөгөөд 1960 оноос хойших цаг хугацаа нь «Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ»-ний эрх зүйн хүрээнд хамаарах юм.

<sup>1</sup> Энэхүү илтгэл нь Н.Алтантөгс, Монгол-Хятадын социалист найрамдлын мандал, буурлын түүх, Улаанбаатар: МУИС Пресс, 2019 номын судалгааны үр дүнг агуулсан.

## Улаанбаатар-Жининий төмөр зам байгуулах шийдвэр

БНМАУ-БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр нь Улаанбаатар-Жининий төмөр замыг барьж байгуулах тухай Монгол, Зөвлөлт, Хятад гурван улсын удирдагчдын яриа хэлэлцээрийн дараахан байгуулагдсан ба энэ хоёр хэлэлцээр нь хоорондоо нягт уялдаатай тул эн тэргүүнд төмөр замын хэлэлцээрийн талаар бага зэрэг тодруулан авч үзье.

1952 оны 8 дугаар сард Хятадын Ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны сайд Жоу Энълай Москвад айлчилж, И.Сталинтай уулзжээ. Уулзалтаар Монгол-Хятадын хил хүртэл төмөр зам барих талаар ярилцсан байна. 8 дугаар сарын 20-нд болсон тус уулзалтаар Жоу Энълай Улаанбаатар-Жининий төмөр замыг барьж байгуулах нь Хятадын сонирхолд тохирч байгааг тэмдэглээд, уг төмөр зам нь ЗХУ-тай төмөр замын харилцааны шууд замыг нээж, Зөвлөлтөөс үйлдвэрийн тоног төхөөрөмж авах, түүнчлэн Хятадын бараа таваарыг Зөвлөлтөд тээвэрлэн хүргэхэд хөнгөвчилж өгөх ач холбогдолтой гэжээ. Жоу Энълайгийн зүгээс Шинжаанаар дамжуулан шууд төмөр зам тавихыг сонирхож байсан ч энэ нь бүтээн байгуулалтын хувьд хэт нүсэр тул ихээхэн цаг хугацаа, хөрөнгө хүч шаардлагатай тул тэргүүн ээлжийн асуудал биш байв. Харин И.Сталины зүгээс Улаанбаатараас Хятад руу төмөр зам тавихыг дэмжих болсон бөгөөд улмаар хэрэв Монголоор дайруулан төмөр зам тавихыг хятад нөхөд сонирхож байгаа бол бид туслахад бэлэн гэж мэдэгдсэнээр Зөвлөлт, Хятад хоёр улс Улаанбаатар-Жининий төмөр замыг бүтээн байгуулах талаар дээд хэмжээнд санал нэгджээ<sup>2</sup>.

Хэлэлцээрийн үеэр Монгол улсын ерөнхий сайд Ю.Цэдэнбал Москвад айлчилж, Хятадын хил хүртэл төмөр зам тавих тухай Зөвлөлт-Хятад-Монголын хэлэлцээрт оролцов. Хэлэлцээр эхлэхийн өмнө 1952 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр И.Сталин Ю.Цэдэнбалыг тусгайлан хүлээн авч уулзаж, Монгол-Хятадын харилцаа ямар байгааг сонирхжээ. Ю.Цэдэнбал хариулахдаа “Муугүй байгаа. Урьд нь муу байсан, одоо сайжирч байна” гэв. И.Сталин “Энэ ч аргагүй, учир нь урьд нь хятадууд та нарыг идэхийг хүсдэг байсан. Одоо бол Хятадад сайн засгийн газар байгуулагдсан” гэж хэлжээ<sup>3</sup>. Мөн И.Сталин Улаанбаатар-Жининий төмөр зам Монгол улсад хэр ашигтай байхыг сонирхов. Ю.Цэдэнбал “Зам маш их ашиг өгнө” гэж хариулахад И.Сталин “Үүнээс хятадууд ч хожно, учир нь энэ зам Зөвлөлтийн тоног төхөөрөмжийг Хятадад хүргэхэд хөнгөвчилнө” гэжээ<sup>4</sup>. Ингэснээр И.Сталины санаачилгын дагуу Монгол-Хятадыг холбосон төмөр зам байгуулах улс төрийн шийдвэрт гурван улсын удирдагчид санал нэгджээ.

<sup>2</sup> Сталин ба Монгол орон (баримт бичгийн эмхэтгэл), УБ., 2010, 300-р хуудас.

<sup>3</sup> Сталин ба Монгол орон (баримт бичгийн эмхэтгэл), УБ., 2010, 304-р хуудас.

<sup>4</sup> Сталин ба Монгол орон (баримт бичгийн эмхэтгэл), УБ., 2010, 304-р хуудас.

1952 оны 9 дүгээр сарын 15-нд “БНХАУ, ЗСБНХУ, БНМАУ хоорондын төмөр замын хамтарсан дамжин өнгөрүүлэх тээвэр зохион байгуулах тухай хэлэлцээр” байгуулж, Зөвлөлтөөс А.Я.Вышинский, Хятадаас Жоу Энълай, Монголоос Ю.Цэдэнбал нар гарын үсэг зурав.<sup>5</sup> Тус хэлэлцээрээр дараах зүйлийг тохирчээ. Үүнд:

1. Жинин-Эрээний төмөр замыг БНХАУ, Улаанбаатар – Замын-Үүдийн төмөр замыг Зөвлөлт-Монголын хэлэлцээрийн дагуу Зөвлөлт ба БНМАУ хариуцаж барина.
2. Төмөр зам нь дан замтай байх бөгөөд нийт 1524 км урттай, хоногт 12 вагон нэвтрэх хүчин чадалтай байна.
3. Төмөр замыг 1953 онд барьж эхлээд 1955 онд багтааж ашиглалтад оруулна.

Ийнхүү Зөвлөлт-Хятадыг холбосон шинэ төмөр замыг Монголын нутаг дэвсгэрээр дайруулан барьж байгуулахаар шийдвэрлэснээр Улаанбаатар-Жининий хооронд томоохон бүтээн байгуулалт эхлэв. Улаанбаатар-Жининий төмөр зам бол Монгол-Зөвлөлт-Хятад гурван улсын хамтарсан хамгийн том бүтээн байгуулалт болсон билээ.

Улаанбаатар-Жининий төмөр замыг барьж байгуулахаар шийдвэрлэж, барилгын ажил удалгүй эхэлсэн явдал нь Монгол-Хятадын хооронд эдийн засаг, соёлын талаар өргөн хүрээнд хамтран ажиллах урьдач нөхцөлийг бүрдүүлэв.

### **Монгол, Хятадын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр**

Төмөр замын хэлэлцээр байгуулагдсанаас нэг сар хүрэхгүй хугацааны дараа, 1952 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Ю.Цэдэнбал, Жоу Энълай нар Бээжин хотноо гарын үсэг зурсан БНМАУ-БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт тус хоёр улсын хооронд эдийн засаг, соёл, боловсролын талаар хамтын ажиллагааг тогтоож хөгжүүлэн бэхжүүлэх ба тус хэлэлцээрийг үндэслэн, мөн үүнийг биелүүлэх журмаар Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын аж ахуй, худалдаа, соёл-гэгээрлийн зохих албан газруудын хооронд жич тодорхой хэлэлцээрүүд тогтоогдохоор тохиров. Тус хэлэлцээр нь 1962 оныг хүртэл 10 жилийн хугацаатай бөгөөд хэрэв аль нэг тал хэлэлцээрийг цуцлах санал гаргаагүй бол цааш 1972 он хүртэл ахин 10 жилээр сунгагдах ажээ.

Монгол-Хятадын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр нь Монгол, Хятадын ард түмний харилцааны түүхэнд нэн чухал ач холбогдолтойг хоёр талын удирдагчид тэмдэглэн хэлж байлаа. Гэрээ байгуулсны дараа

<sup>5</sup> Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл, 2-р хэсэг, 1949-2003 он, УБ., 2003. 34-35-р хуудас.

Монгол улсын ерөнхий сайд Ю.Цэдэнбал хэлэхдээ “Дэлхийн улс түмний тэгш эрхийн зарчмын үндсэн дээр хоёр орны ард түмний найрамдал, энх тайвны үзэл санаа нэвт шингэсэн энэ гэрээ БНМАУ, БНХАУ-ын ард түмний эрх ашиг, хүсэл сонирхолд бүрэн нийцэж байгаа бөгөөд манай ард түмнүүдийн жинхэнэ, ах дүүгийн харилцааны тод баталгаа болж байна” гэж мэдэгдэв<sup>6</sup>. Мөн «Рэнмин Рибо» сонинд «Хятад, Монголын найрамдалт харилцааны шинэ хөгжилт» гэсэн тэргүүн өгүүлэл нийтлэгдэв.

1952 оны 11 дүгээр сарын 15-нд БНХАУ-ын Засгийн газрын 19 дүгээр хурлаар «Хятад-Монголын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийг баталж, 12 дугаар сарын 29-нд батламж бичгийг солилцох ёслол Улаанбаатар хотноо болсноор хүчин төгөлдөр үйлчилж эхлэв. Тус хэлэлцээр нь хоёр улсын хооронд цааш цаашдын олон гэрээ, хэлэлцээр байгуулах үндэс болов. Энэ хэлэлцээрийн үндсэн дээр тус хоёр улсын хооронд 1953 онд «Бараа гүйлгээ, төлбөрийн тухай хэлэлцээр» ба «Харилцан бараа нийлүүлэх гэрээ», 1955 онд «Ажиллах хүчний тухай хэлэлцээр», 1956 онд БНХАУ-ын Засгийн газраас БНМАУ-д зориулж 160 сая рублийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай, 1958 онд БНХАУ-аас 100 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгох тухай зэрэг хэлэлцээрүүд байгуулагдаж, хоёр улсын харилцаа амжилттай хөгжсөн билээ. БНМАУ, БНХАУ-ын хооронд 1960 онд «Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ» байгуулагдах хүртэл эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр нь тус хоёр улсын харилцаанд баримтлах үндсэн баримт бичиг байв.

### **1953 оны Бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээр**

1953 оны «Бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээр» нь эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн шууд үр дүн болсон баримт бичиг юм. Дэлхийн хоёрдугаар дайны дараа социалист блок бий болсноор ардын ардчилсан орнуудын хооронд улсын өмчид тулгуурласан худалдааны хэлбэр тархжээ. Энэ загвар нь Монгол-Зөвлөлтийн хооронд 1930 оноос эхлэн тогтсон худалдааны загварт үндэслэжээ. Энэ загварыг дараах гурван зүйлээр тодорхойлж болно.

/1/ Хоёр улсын худалдаанд жил тутмын худалдааны гэрээ байгуулж, түүний хавсралтад нэг бүрчлэн нэр, тоо хэмжээ, чанарыг тодорхойлж заасан барааг харилцан нийлүүлнэ.

/2/ Хоёр улсын хооронд худалдах барааны үнийг хоёр тал харилцан зөвшилцсөний үндсэн дээр Зөвлөлтийн рублиэр тогтооно.

/3/ Хоёр улсын хоорондын харилцан бараа нийлүүлэх гэрээг худалдаа эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Ихэнхдээ Гадаад худалдааны

<sup>6</sup> Вопросы Истории, 1953, №9, 73-р хуудас.

яам) хооронд байгуулж, улсын өмчит худалдааны компаниудаар дамжуулан гүйцэтгэнэ. Тухайлбал, Монгол-Зөвлөлтийн харилцан бараа нийлүүлэх гэрээг ЗХУ-ын Гадаад худалдааны яам, БНМАУ-ын Гадаад худалдааны яам хооронд байгуулж, худалдааны явцыг Монголын талаас нийтийн өмчит «Хоршоодын төв холбоо» хэмээх худалдааны байгууллага, Зөвлөлтийн талаас Гадаад худалдааны яамны харьяа Совмонголторг, Малимпорт зэрэг худалдааны нэгдлүүд буюу компаниуд зохион байгуулж, хэрэгжүүлж байв.

1950-1951 онд сууриа тавьсан шинэ үеийн Монгол-Хятадын худалдаа нь харилцан бараа нийлүүлэх зарчмаар өрнөж байсан хэдий ч нийлүүлэх барааг нэгтгэсэн хэлэлцээргүй ба барааны төлбөрийн журмыг эцэслэн шийдээгүй байв.

1952 оны 9 дүгээр сард Монгол, Хятадын хооронд «Эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» байгуулсны дараа Хятадын ГХЯ-наас хоёр улсын хооронд худалдааны ерөнхий хэлэлцээр байгуулах асуудлыг боловсруулах тухай санал тавьсныг Монголын тал зөвшөөрч, хоёр улсын хооронд ерөнхий хэлэлцээр байгуулах ба түүнтэй холбогдуулан харилцан солилцох барааны жагсаалт гаргаж 1952 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Хятадын ГХЯ-нд илгээжээ<sup>7</sup>.

Үүний дараа 1953 оны 5 дугаар сард Монголын Гадаад худалдааны яамны төлөөлөгчид Бээжинд хүрэлцэн очиж, Худалдааны ерөнхий хэлэлцээр ба 1953 оны харилцан бараа нийлүүлэх гэрээг хэлэлцэж эхлэв. Яриа хэлэлцээ нэлээн удаан үргэлжилж, 8 дугаар сард дуусаж, Монгол-Хятадын бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Яриа хэлэлцээ ингэж удаан үргэлжилсэн явдал нь хэлэлцэх асуудал ба Монголын төлөөлөгчдийн статуст өөрчлөлт орсонтой холбоотой байв. Монголын төлөөлөгчид Гадаад худалдааны яамны төлөөлөгчийн статустайгаар зөвхөн 1953 оны харилцан бараа нийлүүлэх гэрээ байгуулах зорилгоор Бээжинд очсон ба харин Хятадын тал тэднийг Засгийн газрын худалдааны төлөөлөгчдийн статусаар хүлээн авч, хоёр улсын хооронд төлбөрийн хэлэлцээр байгуулах тухай асуудлыг дэвшүүлсэн байна.<sup>8</sup> Иймээс Монголын төлөөлөгчид эргэж төв рүүгээ холбогдон энэ талаар лавлаж зөвшөөрөл авснаар 1953 оны 5 дугаар сарын 22-ноос эхлэн Гадаад худалдааны яамны биш, Засгийн газрын худалдааны төлөөлөгчийн статустайгаар Хятадын Гадаад худалдааны яамны албаны хүмүүстэй уулзаж, төлбөрийн хэлэлцээрийг боловсруулж эхэлжээ<sup>9</sup>. Ийнхүү Монголын төлөөлөгчид Бээжинд хүрэлцэн очсон хойно урьдчилан төлөвлөөгүй байсан төлбөрийн хэлэлцээрийн асуудал ажлын төлөвлөгөөнд орж ирснээс шалтгаалж уг хэлэлцээрийг боловсруулах, санал солилцох зэрэг техникийн шинжтэй үйл ажиллагаа эхэлж, гурван сар үргэлжилжээ.

<sup>7</sup> МУУТА, ф-38, д-1, хн-917, 1-4-р хуудас.

<sup>8</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 210-214-р хуудас.

<sup>9</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 226-227-р хуудас

Ингээд 1953 оны 8 дугаар сарын 20-ны өдөр «БНМАУ-ын Засгийн газар ба БНХАУ-ын Ардын Төв Засгийн Газрын хооронд 1953 оны бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээр»-т гарын үсэг зуржээ. Хэлэлцээр 11 зүйлтэй бөгөөд 1953 онд Монголоос Хятадад 6.8 сая рубль, Хятадаас Монголд 1.3 сая рублийн бараа нийлүүлэх, худалдааны төлбөрийг хоёр улсын банкаар дамжуулах, тооцоонд рубль хэрэглэх болон бусад холбогдох асуудлыг тохирсон байна.

Тус хэлэлцээрээр 1953 онд худалдах Монголын гол бараа 20 мянган толгой адуу ба 100 мянган ширхэг шевро бол Хятадын гол бараанууд нь үйлдвэр, албан байгууллагуудын хэрэгцээний бараанууд байв. Жишээ нь нэгэн жилд дундыг баримталбал 180 сая хүртэл хайрцаг чүдэнз үйлдвэрлэх фабрикийн бүх машин 32 ш, жилд 400 тн саван гарах чадвар бүхий савангийн заводын бүх машин, янжуурын машин, сонин хэвлэх, цаас огтлох машин, арьс ширэн зүйл дээр хээ гаргах машин, юм угаах ба хатаах машин, гар үйлдвэрийн сийлбэрийн хутгууд гэх мэтийн үйлдвэрийн багаж хэрэгслүүд, будаг, маажин, паалан, яс гэх мэтийн үйлдвэрийн материалууд, зургийн хэрэглэл, зочид буудлын хэрэглэл, торгон нэхмэл гэх мэтийн соёл урлаг, албан байгууллагуудын хэрэгцээний бараануудыг Хятадаас Монголд нийлүүлэхээр болжээ.<sup>10</sup> Барааны тээврийн зардлыг хоёр улсын хил хүртэл нийлүүлэгч тал хариуцах бөгөөд хилээс цааш тээврийг хүлээн авч буй тал хариуцахаар тохирчээ.

Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд барааны үнийн төлбөр мөн солилцож байгаа барааны тээврийн ба бусад төлбөрийн талаар Хятадын талаас Хятад Улсын Ардын Банкаар, Монголын талаас Монгол Банкаар дамжуулан гүйцэтгэнэ хэмээн заажээ. Энэ хэлэлцээрийн үр дүнд худалдааны төлбөрүүдийн тооцоог яаж хийх тухай үндсэн зарчмыг шийдвэрлэсэн явдал нь тус хоёр улсын хооронд цаашид худалдааны ямар нэг асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн дөхөмтэй болжээ. Тус хэлэлцээр 1953 оныг дуустал хүчинтэй бөгөөд үлдэгдэл тооцоог 1954 оны 6 дугаар сарын 30-ны дотор дуусгахаар тохирчээ.<sup>11</sup>

Монголын тал хэлэлцээрийн явцад “Манай хүсэлтийг бүрэн хангахын тулд Хятадын Гадаад худалдааны яам ба түүний харьяа байгууллагууд нь маш ихээхэн идэвх санаачилгатайгаар ажилласан болно. Манай хүсэлтийг бүрэн хангах явдалд гагцхүү бидний захиалсан барааг хангах биш түүний яс чанар, өнгө зүс болон бүх талаар нь манай хэрэгцээнд тохируулахыг маш их анхааран үзэж танилцуулав” хэмээн онцлон тэмдэглэж байв.<sup>12</sup>

Хэлэлцээрт гарын үсэг зурах үед БНХАУ-ын Гадаад худалдааны яамны орлогч сайд Ми Же-жин “Монголоос Хятадад нийлүүлж байгаа адуу

<sup>10</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 160-166-р хуудас.

<sup>11</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 65-70-р хуудас.

<sup>12</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 160-166-р хуудас

бол Хятадын улсыг батлан хамгаалах явдлыг хүчтэй болгох ба бүтээн байгуулалтын хэрэгт чухал ролийг үзүүлэх юм” хэмээн Монголоос худалдан авч буй адууны худалдааны ач холбогдлыг өндрөөр үнэлжээ.<sup>13</sup>

Монгол-Хятадын бараа гүйлгээ, төлбөрийн тухай хэлэлцээр нь тус хоёр улс дэлхийн социалист системийн орнуудын хооронд нэгэнт үүсэж тогтсон харилцан бараа нийлүүлэх рублийн системд нэгдэн орсныг харуулав. Төлбөр тооцоог нэгтгэн журамлаж, тооцоондоо рублийг хэрэглэх болсон, бараа тээврийн зарчмыг шийдвэрлэсэн, бүтэн жилийн хугацаанд нийлүүлэх барааг тусгайлан хавсралтаар жагсааж баталсан зэрэг нь цаашид тус хоёр улсын худалдаа социалист системийн орнуудын адил хөгжих нэг үндэс болжээ.

### **Харилцан бараа нийлүүлэх гэрээ**

Худалдаа нь Монгол-Хятадын харилцааны нэгэн чухал салбар, ялангуяа монголчуудын хувьд Хятадаас чухал хэрэгцээтэй бараа, таваараа хямд үнээр худалдаж авах чухал ач холбогдол бүхий харилцаа байв. Монгол-Хятадын худалдаа 1950-1951 онд зохих хэмжээгээр явагдаж байсан боловч бага хэмжээтэй байсан бөгөөд 1953 оны бараа гүйлгээ, төлбөрийн тухай хэлэлцээрээр өсөж эхэлсэн билээ. Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт 1952 онд 1961 оны ханшаар 1.4 сая рубль байсан бол 1953 онд мөн 1961 оны ханшаар 2.6 сая, 1954 онд 2.4 сая, 1955 онд 3.6 сая рубль болж өсжээ.<sup>14</sup>

1953-1955 онд Монгол-Хятадын худалдаанд бий болсон харилцан бараа нийлүүлэх гэрээг байгуулах үйл явц, түүнийг хэрэгжүүлэх журам нь 1960-аад он хүртэл Монгол-Хятадын худалдааны үндсэн хэв загварыг тодорхойлж байсан бөгөөд түүнээс гадуур ямар нэгэн худалдаа явагддаггүй байв.

Монголын төлөөлөгчид Бээжинд очихдоо 1953 онд 5 сая хуучин рублийн үнэ бүхий адуу Хятадад нийлүүлэх, харин 1 сая хуучин рублийн бараа Хятадаас авахаар төлөвлөсөн байв. Хэлэлцээрийн явцад энэ байдал Хятадын талын саналаар өөрчлөгдөж, Монголын авах бараа нэмэгдсэн байна. Хятадын Гадаад худалдааны яамны 1 дүгээр товчооны дарга Бай 1953 оны 5 дугаар сард Монголын худалдааны төлөөлөгчидтэй хийсэн уулзалт дээр Хятадын Гадаад худалдааны яам гадаад улсад худалдааны өргүй байхыг хүсэж буйг илэрхийлээд “Танай хэрэгцээт барааг аль аль талдаа бололцоотой нөхцөлөөр хангаж өгөхийг бодно. Жишээ нь торгыг ЗХУ-д өгдөг бөгөөд тэр үнээр торгыг өгч болно. Үнэтэй гэж үзвэл хямдруулан өгч ч болно” хэмээн торгоор жишээ болгон худалдааны таатай нөхцөлийг санал болгожээ.<sup>15</sup> Ингээд Монголын төлөөлөгчид төвтэйгөө холбогдож зөвлөлдсөний үндсэн

<sup>13</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 156-р хуудас.

<sup>14</sup> Дугаржав, БНМАУ-БНХАУ-ын худалдаа эдийн засгийн харилцааны тухай илтгэл, танилцуулга, БНМАУ-ын Гадаад Худалдааны Яам, 1968 оны 5 сарын 20. МУУТА, ф-38, д-1, хн-917, 1-9-р хуудас.

<sup>15</sup> МУУТА, ф-38, д-1, хн-13, 244-р хуудас.

дээр Хятадаас авах барааны нэр, төрлийг нэмж, 1953 онд нийт 6.8 сая хуучин рублийн барааг Хятадаас авахаар тохиролцож, Хятадын талын санаачилгын дагуу хоёр улсын бараа нийлүүлэлт тэнцвэржив.

1954 онд Монгол-Хятадын харилцан бараа нийлүүлэх гэрээг ахин байгуулж, Монголын тал Хятадад 10 мянган морь, Хятадын тал Монголд торго, арьсан эдлэл ба хуурай, шинэ жимс зэрэг бараа экспортлохоор болов.<sup>16</sup>

1955 оны харилцан бараа нийлүүлэх гэрээ байгуулах хэлэлцээ 1954 оны 10 дугаар сарын 12-ноос 12 дугаар сарын 16 хүртэл Бээжинд явагдсан бөгөөд Хятадын талаас ГХЯ-ны сайдын орлогч Шү Шүэхан хэлэлцээг удирдаж, яамны 1 дүгээр товчоо, Экспортын товчоо, Импортын товчооны дарга, орлогчид ба Хятадын экспорт-импортын улсын компаниудын дарга, орлогчид жинхэнэ хэлэлцээний ажилд голлон оролцов. Хэлэлцээний үр дүнд Хятад-Монголын хооронд 1955 онд харилцан бараа нийлүүлэх тухай Засгийн газрын протокол ба түүний үндсэн дээр хоёр улсын гадаад худалдааны байгууллагууд бараа солилцох тухай найман гэрээнд гарын үсэг зуржээ. Тус протокол ёсоор Монголоос Хятадад 7.6 сая хуучин рублийн бараа, Хятадаас Монголд 7.9 сая хуучин рублийн барааг 1955 онд нийлүүлэхээр болов.<sup>17</sup>

1955 оны тухайд харилцан бараа нийлүүлэх гэрээний цар хүрээ, барааны нэр төрөл нэлээн өргөссөн байна. Үүнд урьдын адил Хятадын талын санаачилга голлон нөлөөлжээ. Хэлэлцээний явцад Хятадын талаас Монголын талын саналд ороогүй зарим зүйлийг нэмж өгөхийг хүсжээ. Үүнд, 8 мянган адуу, 300 мянган хурганы арьс, 200 мянган сэгсүүргэн арьс, 20 мянган адууны шир, 10 мянган нохойн арьс зэргийг хүссэнд Монголын тал адууны хүсэлтийг бүрэн, нохойн арьс, мануулын арьсны талыг, сэгсүүргэн арьс, адууны ширний багахныг тус тус биелүүлжээ. Харин хурганы арьс, ямааны арьс, хонины нэхий, шилүүсний арьсыг түүхий эдийн нөөц хангалтгүй тул Хятадад нийлүүлэхээс татгалзжээ.<sup>18</sup>

1955 оны харилцан бараа нийлүүлэх нэр төрөл ба тоо хэмжээ нь 1954 оныхоос нэлээн нэмэгдсэн бөгөөд ялангуяа Монголын талаас хатаасан мөөг, хунчир өвс, тарваганы доод дугаарын арьс зэрэг шинэ зүйлүүдийг гаргах болов. Хоёр талын худалдаалах барааны нэр, төрөл олшроход Хятадын Гадаад худалдааны яам ба худалдааны компаниудын идэвх зүтгэл чухал үүрэг гүйцэтгэснийг Монголын худалдааны төлөөлөгчид онцлон тэмдэглэж, талархал дэвшүүлж байв.<sup>19</sup>

1953 оноос эхлэн жил бүр БНМАУ-ын Гадаад худалдааны яам, БНХАУ-ын Гадаад худалдааны яамны хооронд харилцан бараа нийлүүлэх гэрээ хийх болов. Хятад улс Монголоос худалдан авах адууны тоог нэмэгдүүлэхийг

<sup>16</sup> Известия, 1954 оны 4 сар.

<sup>17</sup> МУУТА, ф-1, д-5, хн-854, 1-4-р хуудас.

<sup>18</sup> МУУТА, ф-1, д-5, хн-854, 5-р хуудас.

<sup>19</sup> МУУТА, ф-1, д-5, хн-854, 6-р хуудас.

эрмэлзэж байсан бол Монгол улс Хятадаас авах барааны нэр төрөл, үнийн дүнг өсгөх, гэхдээ Зөвлөлтөөс худалдан авдаг бараануудыг Хятадаас худалдан авахгүй байх бодлого барьж байв.

### **Транзит тээврийн төлбөрийг худалдааны тооцоонд оруулсан нь**

1956 оны худалдааны хэлэлцээр 1955 оны 11 дүгээр сард Бээжин хотноо явагдсан бөгөөд уг хэлэлцээрийн үндсэн асуудал нь Монголоос Хятадад нийлүүлэх адууны тоог 47 мянга болгож нэмэгдүүлэх, транзит тээврийн төлбөрийг Монгол-Хятадын худалдаанд шилжүүлж уг төлбөрийн оронд Хятадаас бараа нийлүүлэх, тус хоёр улсын худалдаанд баримталж буй үнийг Зөвлөлт-Хятадын худалдааны үнэтэй адил болгож жигдлэх зэрэг асуудлууд байв.<sup>20</sup>

Монголын худалдааны төлөөлөгчид 1956 онд Хятадад 25 мянган адуу худалдахаар төлөвлөж байтал Хятадын талаас уг адууг эхлээд 32 мянга, дараа нь 47 мянга болгож өсгөх хүсэлт тавьжээ. Монгол дахь Хятадын элчин сайд Хө Ин Монголын Ерөнхий сайдын орлогч Аварзэдтэй 1955 оны 12 дугаар сарын 1-ний өдөр уулзахдаа "Монголоос Хятадад олон мянган адуу худалдаж тусалсан нь хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөхөд их тус болж байгаа ба хятад тариачид монгол морьдыг бие багатай ч хүч чадал ихтэйг гайхан магтаж байна" хэмээн дурдаад Монголоос авах адууны тоог 47 мянга болгож нэмэгдүүлж өгөхийг хүсжээ.<sup>21</sup> Адууны тухай асуудлыг Монголын Засгийн газрын түвшинд хэлэлцэж, 1955 оны 12 дугаар сарын 10-нд хүсэлтийг хүлээн авч буйгаа элчин сайд Хө Инд мэдэгдсэнээр 1956 онд түүхэн дээд хэмжээ буюу 47 мянган адууг Хятадад худалдахаар болжээ. Энэ олон адууг нэг чиглэлээр гаргах боломжгүй тул Ховд аймгийн Булган голын чиглэлээр 7,000 мянган адуу, Замын-Үүдээр 33,500 адуу, Ламын хийдээр 6,500 адуу худалдахаар төлөвлөжээ.<sup>22</sup>

Худалдааны хэлэлцээний үеэр Хятадын талаас үнийн асуудлыг хөнджээ. Хятадаас Монголд худалдаж буй зарим барааны үнэ Хятадаас Зөвлөлтөд байгаа мөн барааны үнээс өндөр байгаа тул үнийг хасагдуулан Зөвлөлтөд гаргаж байгаатай ижил болгохоо Хятадын тал мэдэгдээд, харин Монголын барааны талаар саналаа гаргахыг Монголын төлөөлөгчдөөс шаарджээ.

Монголын төлөөлөгчид уг зүйлийг зөвшөөрч, Монголоос Хятадад худалдаж буй зарим барааны үнэ Зөвлөлтөд гаргаж буй мөн барааны үнээс өндөр байгаа явдлыг арилгах, ингэхдээ тээврийн хол зайг бодолцож Зөвлөлтөд гаргах үнээс 2 хувиар өндрөөр тогтоохоор төлөвлөжээ. Учир нь барааг Улаанбаатараас Зөвлөлтийн хил хүртэл 402 км, Хятадын хил хүртэл

<sup>20</sup> МУУТА, ф-11, д-2, хн-218, 118-120-р хуудас.

<sup>21</sup> МУУТА, ф-1, д-5, хн-794, 14-18-р хуудас.

<sup>22</sup> МУУТА, ф-1, д-5, хн-794, 11-13-р хуудас.

730 км тээвэрлэх тул уг тээврийн өртгийг үүнд шингээн тооцжээ.<sup>23</sup> Ингэснээр 1956 оноос эхлэн тус хоёр улсаас хоорондын худалдаандаа Зөвлөлт улстай хийж буй худалдааны үнийг суурь болгон баримтлах зарчим тогтжээ.

1956 оны худалдааны хэлэлцээрийн дараагийн чухал асуудал бол транзит тээврийн төлбөрийг худалдаанд шилжүүлэн тооцох тухай байв. 1956 онд Монгол-Хятадын худалдааны төлөөлөгчид 1956 онд харилцан бараа нийлүүлэх гэрээг хэлэлцэж байх үеэр Монголд төлөх дамжин өнгөрөх тээврийн төлбөрийн асуудлыг Хятадын талаас санаачлан хөнджээ. Худалдааны хэлэлцээрийн үеэр Монголын тал 1956 онд Хятадын талд 10 сая рублийн бараа нийлүүлж, Хятадаас мөн 10 сая рублийн бараа авахаар төлөвлөөд байв. Харин Хятадын тал Улаанбаатар төмөр замаар дамжуулан ачаа тээвэрлүүлсний төлбөр 32 сая хуучин рублийг (7.2 сая шинэ рубль) Монголын талд бараа нийлүүлэх журмаар төлөх санал гаргав.<sup>24</sup>

Үүний урьд Монголын Улсын Төлөвлөгөөний Комиссоос 1956-1960 онд улс, ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөндөө улсын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэхийн тулд Улаанбаатар төмөр замаар дамжин өнгөрөх тээврийн төлбөрт Хятадаас 1956 онд 14 сая, 1957 онд 30 сая, 1958 онд 32 сая, 1959 онд 35 сая, 1960 онд 40 сая хуучин рублийг тус тус авч, Монгол-Зөвлөлтийн хамтарсан Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгт орлого болгохоор төлөвлөж байв. Тус хөрөнгөнөөс Монголын Засгийн газарт оногдох хувийг улсын төсвийн орлого болгохоор Улсын Төлөвлөгөөний Комиссоос санал болгосон бөгөөд энэ талаар Зөвлөлтийн Засгийн газарт хандаж хүсэлт тавихаар төлөвлөж байжээ.<sup>25</sup>

Хятадын талын гаргасан санал нь Монголын Улсын Төлөвлөгөөний Комиссын урьдын төлөвлөж байсантай бүрэн нийцэж буй тул Монголын төлөөлөгчид үүнийг Засгийн газартайгаа зөвшилцсөний үндсэн дээр зөвшөөрчээ. Монголын Засгийн газраас 1956 онд Зөвлөлтийн Засгийн газартай харилцаж тохиролцсоноор Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгт Хятадын талын төлөх төлбөрийг Хятадаас худалдан авсан барааны төлбөрт шилжүүлэн тооцох эрх зүйн үндэс бий болов.

Транзит тээврийн төлбөрийн асуудал худалдааны тооцоонд шилжин орж ирснээр Монголын тал Хятадаас 1956 онд шинээр 10.9 сая хуучин рублийн бараа, урьд захиалсан нэр төрлийн бараагаа нэмэгдүүлж 4.7 сая хуучин рублийн барааг нэмж авахаар шийдвэрлэв.<sup>26</sup> Энэ нь хоёр улсын худалдаа ялангуяа Хятадаас Монголд худалдах бараа нэмэгдэх гол нөхцөл болов.

<sup>23</sup> МУУТА, ф-11, д-2, хн-218, 119-р хуудас.

<sup>24</sup> МУУТА, ф-11, д-2, хн-218, 118-р хуудас.

<sup>25</sup> МУУТА, ф-11, д-2, хн-218, 204-209-р хуудас.

<sup>26</sup> МУУТА, ф-11, д-2, хн-218, 118-р хуудас.

**1956-1960 оны Монгол-Хятадын худалдааны эргэлт**

1956-1960 онд Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт их хэмжээгээр өсөж, 1960 онд 120.56 сая хуучин рубль болж, Монгол-Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойших хугацааны хамгийн өндөр үедээ очжээ.

**Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт, 1956-1960 он***Сая хуучин рублиар<sup>27</sup>*

Он	Нийт эргэлт	Монголын экспорт	Монголын импорт	Гадаад худалдааны тэнцэл	Хятадаас Монголд төлсөн транзит тээврийн төлбөр	Төлбөрийн тэнцэл
<b>1956 он</b>	41.36	14.08	27.28	-13.20	13.20	0.00
<b>1957 он</b>	62.48	17.60	44.88	-27.28	26.84	-0.44
<b>1958 он</b>	72.60	10.56	62.04	-51.48	51.48	0.00
<b>1959 он</b>	96.36	11.88	84.48	-72.60	75.68	3.08
<b>1960 он</b>	120.56	12.76	107.80	-95.04	80.52	-14.52

Эх сурвалж: МУУТА, ф-38, д-1, хн-917, 1-4-р хуудас.

Тус хоёр улсын худалдааны нийт эргэлт 1960 онд 1956 оныхоос гурав дахин нэмэгдсэн нь Хятадаас авах Монголын импорт 27.28 саяас 107.8 сая болж өссөнтэй холбоотой. Энэ явцад Монголын талд 13-95 сая хуучин рублийн их хэмжээний төлбөрийн алдагдал үүссэн мэт харагдах боловч энэ нь Хятадаас Монголд төлөх транзит тээврийн төлбөрийг бараагаар авч, энэ нь Монголын импортын дүнг өсгөж байснаас шалтгаалжээ. Өөрөөр хэлбэл Монголын талын төлбөрийн тэнцэлд үүссэн их хэмжээний алдагдал нь Хятадаас Монголд төлж байсан транзит тээврийн төлбөрөөр тэнцвэржиж байжээ. Транзит тээврийн төлбөрийг оруулан тооцвол тус хоёр улсын хоорондох төлбөрийн тэнцэл 1956-1959 онуудад Монголын талд -0.44-өөс +3.08 сая рублийн хооронд тогтвортой байсан ба гагцхүү 1960 онд Монголын тал Хятадад 14.52 сая хуучин рублийн өртэй гарчээ.

Хятад улс 1956-1960 онуудад 12-15 тэрбум хуучин рублийн гадаад худалдаа хийж байснаас Монгол улстай 41-120 сая хуучин рублийн худалдаа хийж, энэ нь Хятадын нийт гадаад худалдааны 0.32-0.79 хувийг эзэлж байв. Хэдийгээр Монголтой хийх худалдаа нь Хятадын гадаад худалдаанд маш бага хувь эзэлж байсан боловч Хятадын умард мужуудад байгуулагдсан нэгдэл, хамтралуудыг хэдэн арван мянган мориор хангах, мөн түүнчлэн Зөвлөлтөд экспортын бараагаа тээвэрлэх зардлыг хөнгөвчлөх ач холбогдолтой байв.

<sup>27</sup> Архивын баримтад мөнгөн дүнг 1961 оны шинэ рублийн ханшаар илэрхийлснийг 1960 оны хуучин рублийн ханшид шилжүүлэв.

**Хятадын гадаад худалдаанд Монголын эзлэх хувь, 1956-1960 он**

	<b>Хятадын гадаад худалдааны нийт эргэлт (сая хуучин рубль)<sup>28</sup></b>	<b>Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт (сая хуучин рубль)<sup>29</sup></b>	<b>Монголын эзлэх хувь</b>
<b>1956 он</b>	12,832	41.36	0.32%
<b>1957 он</b>	12,412	62.48	0.50%
<b>1958 он</b>	15,484	72.60	0.46%
<b>1959 он</b>	17,524	96.36	0.54%
<b>1960 он</b>	15,236	120.56	0.79%

1959 оны байдлаар Хятадтай хийх худалдаа Монголын гадаад худалдааны 15.5 хувь, түүнээс экспортын 4.8 хувь, импортын 23.5 хувийг эзлэх болжээ. Монголын тухайд Монголын өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний худалдаанд хятад барааны эзлэх хувь улам нэмэгдэж, энэ нь Монголын гадаад худалдаанд Хятадын эзлэх хувь 1960 онд 17.8 хувь хүртэл өсөн нэмэгджээ.

Үүний үр дүнд 1960 он гэхэд Монголын гадаад худалдаанд Зөвлөлтийн эзлэх хувь 50-60 хувь болж буурч, харин Хятадтай хийх худалдаа 17.8 хувь, Дорнод Европын орнуудтай хийх худалдаа 20-30 хувь болон өсч, Монголын дотоодын бараа хангамж, тоног төхөөрөмж, сэлбэг материалын олдоц хүртээмж сайжрав.

**Ажиллах хүч**

Монгол-Хятадын харилцаанд ажиллах хүчний тухай асуудал анх 1950 онд хөндөгджээ. Монгол улсын ерөнхий сайд Х.Чойбалсан 1950 оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо суух БНХАУ-ын элчин сайд Заяатад хандан Хятад улсаас ажиллах хүчин авах хүсэлтийг тавьж байв. Энэ нь гадаад улс шинэ Хятад улсаас тусламж хүссэн анхны хүсэлт болжээ.<sup>30</sup> Шинэ Хятад улс байгуулагдаад нэг жил ч болоогүй, эдийн засаг хүнд байж, Солонгосын дайн дэгдсэн зэрэг шалтгаанаар тухайн үед Монголын талын саналыг судалж үзэх боломжгүй байв.

Харин 1950-иад оны дунд үе болоход Хятад улсын дотоод байдал бэхжиж, Монголд ажиллах хүчнээр туслах боломжтой болсон байна. Ялангуяа 1952 онд Эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, түүний үндсэн дээр 1953 оноос эхлэн Монгол-Хятадын харилцаа эрчимтэй хөгжиж эхлэв. 1954 онд Хятадын Ерөнхий сайд Жоу Энълай, Ерөнхий сайдын орлогч Улаанхүү нар Монголд айлчилж, эдгээр айлчлалуудаар хэлэлцсэн үндсэн асуудал нь Хятадаас Монголд ажиллах хүч илгээх асуудал болж байв.

<sup>28</sup> 中国对外经济贸易年鉴1984, 北京: 中国对外经济贸易出版社, 1984. 第IV-3页。

<sup>29</sup> МУУТА, ф-38, д-1, хн-917, 1-9-р хуудас.

<sup>30</sup> <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》, 来源: 新民晚报; 作者: 杨丽琼。

1954 оны 11 дүгээр сард БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч Улаанхүү Монголд айлчилж, МАХН-ын XII их хуралд оролцоходоо БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбалтай уулзаж, Хятадын тал Монголд олон тооны ажилчин илгээж туслахад бэлэн буйг илэрхийлжээ. Ю.Цэдэнбал түүний хариуд ойролцоогоор 20 мянган ажиллах хүч авахыг хүсэж буйгаа хэлээд богино хугацаагаар бус, харин байнга оршин суух зөвшөөрөлтэйгөөр ирүүлэх санал тавьжээ. Улаанхүү энэ асуудлыг шууд шийдвэрлэх боломжгүй тул намын хурал дууссаны дараа зөвлөлдөхийг санал болгов. Ийнхүү Улаанхүүгийн айлчлалаар Монголд ажиллах хүч илгээх асуудлыг зарчмын хувьд тохиролцов.<sup>31</sup>

12 дугаар сарын 8-нд ХКН-ын Төв хорооноос МАХН-ын Төв хороонд илгээсэн цахилгаан утсанд “Бид танай хүсэлтэд чадахын хэрээр туслах болно” хэмээн мэдэгдэв. Нэг сарын дараа Монголын тал Улаанбаатар дахь БНХАУ-ын элчин сайдын яаманд 40 мэргэжлийн 12,250 ажилчны жагсаалт гаргаж өгч, багаж хэрэгслийн хамт ирүүлэхийг хүсжээ.<sup>32</sup>

Тухайн асуудлаар Хятадын Гадаад харилцааны яамнаас элчин сайдын яаманд илгээсэн цахилгаан утсанд “Энэ удаагийн Монголын хүссэн ажилчид мэргэжлийн хувьд хэт олон, Монголд илгээх хугацаа нэн богино, үүний сацуу холбогдох асуудлууд маш өргөн... Бүртгэх, илгээх үйл ажиллагаа маш хүндрэлтэй” гэжээ. Иймээс Хятадын саналыг үндэслэн хоёр тал ажиллах хүчний асуудлыг нарийвчлан хэлэлцэхээр тохиров.

1955 оны 2 дугаар сарын 16-нд Монголын бүтээн байгуулалтад Хятад улс ажиллах хүч илгээж туслах тухай Монгол-Хятадын хэлэлцээ Бээжин хотод эхэлж, 4 дүгээр сарын 7-нд хэлэлцээрт гарын үсэг зурах хүртэл хоёр тал нийт 14 удаа хуралджээ. Ингэж олон удаа хуралдсаны шалтгаан нь Монголын талын хүсэлт нэн өвөрмөц байсантай холбоотой байв.

Хэлэлцээрийн үндсэн асуудал нь ажилчдын ажиллах хугацаа болон Хятад руу цалингаа гуйвуулах эсэх асуудал болж байв. Монголын тал тус зөвлөгөөн дээр Хятадаас ирэх ажилчдын тухайд “Гэр бүлийн хамт ирүүлэх, оршин суух хугацаа урт тусмаа сайн”, ажиллах хугацаа “таван жилээс доошгүй”, мөн “монгол ажилчидтай ижил цалинжих, орлого цалингаа бүгдийг Монголд зарцуулах, Хятад руу гуйвуулахгүй байх” зэрэг хүсэлт тавьжээ.

Монголын талын энэхүү хүсэлт нь хятад ажилчдын хамт Монгол улсад ирж амьдрах хүсэлтэй Өвөр Монголчуудыг олноор нь нүүлгэн авчрах, тэднийг Монгол улсад ажил хөдөлмөр эрхлэн амьдруулах зорилготой байсан

<sup>31</sup> Record of Conversation with Prime Minister of the Mongolian People's Republic, Comrade Tsedenbal. (fragments), November 29, 1954, History and Public Policy Program Digital Archive, AVPRF: fond 0111, opis 36, папка 235, delo 3, listy 57-58. Obtained and translated by Sergey Radchenko for CWHHP. <http://digitalarchive.wilsoncenter.org/document/110479>

<sup>32</sup> <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》, 来源: 新民晚报; 作者: 杨丽琼。

бололтой. Харин Хятадын тал ажилчдыг илгээх хугацаа нь хамгийн ихдээ 3 жил, цаашид амьдрах эрх олгох боломжтой гэж үзэж байв.<sup>33</sup>

Хэлэлцээрийн үед Монголын талаас гаргасан гол хүсэлтийн нэг нь хятад ажилчид ар гэртээ мөнгө гуйвуулахгүй, цалингаа зөвхөн Монголд зарцуулах явдал байв. Харин Хятадын тал ажилчдыг ар гэртээ мөнгө гуйвуулахыг хязгаарлах бодолгүй байв. Энэ талаар хэд хэдэн удаа зөвлөлдсөний эцэст хоёр тал хятад ажилчид цалингийнхаа 30 хүртэл хувийг Хятад руу гуйвуулахыг зөвшөөрөхөөр тохирчээ.

Тус зөвлөгөөний тухай Хятадын талын төлөөлөгчид Төрийн Зөвлөлдөө илтгэсэн тайлан дотор

*“Хэлэлцээний явц дунд бидний олон санал батлагдах хүртлээ бүгдийг олонтоо тайлбарлах шаардлага гарсан. Жишээлбэл, манай зүгээс ажилчдын ажиллах хугацаа гурван жил байх, Хятадаас кадр ажилчдыг илгээж, Монголд ажилчдын хэрэг эрхлэх товчоо байгуулах, ажилчид цалингийнхаа 30 хувийг ар гэртээ гуйвуулах боломжтой байх, худалдааны биш дансаар мөнгө гуйвуулах зэрэг саналыг олонтоо тайлбарлаж, санал солилцож байв” гэжээ.*<sup>34</sup>

«БНХАУ-аас БНМАУ-ын бүтээн байгуулалтад ажиллах хүчин илгээж туслах тухай БНХАУ-БНМАУ-ын хэлэлцээр» 1955 оны 4 дүгээр сарын 7-нд батлагджээ. Тус хэлэлцээр дараах үндсэн тохиролцоог агуулжээ. Үүнд:

1. 1955-1956 онд БНХАУ-аас ажилчин, техникч, эмч, соёлын ажилтан, орчуулагч, тогооч зэрэг 12,332 хүнийг илгээх ба үүнээс 1955 онд 8,234 хүн, 1956 онд 4,098 хүнийг Монголд ажиллахаар илгээх.
2. Хятад ажилчид Монголд гурван жил ажиллаж, хугацаа дууссаны дараа нутаг буцаж болох буюу эсхүл Монголд оршин суух эрх авч болно.
3. Хятад ажилчид Монголын хууль ба ёс журмыг хүндэтгэн дагах.
4. Хятад ажилчид интернационалч үзэлтэй, өөрийн эзэмшсэн мэргэжилдээ дадлага, туршлагатай байж, монгол ажилчидтай харилцан туршлага солилцож, харилцан сургах,
5. Хятад ажилчдыг монгол ажилчидтай ижил ажилд ижил цалин олгох, хоол ба байрыг Монголын талаас хангах, хүн бүрд өдөрт таван төгрөгийн тэтгэлэг олгох, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хөдөлмөр, нийгмийн даатгалыг үнэгүй хүртэх,
6. Хятад ажилчид Монголд ажиллах хугацаандаа сар бүр өөрийн цалингийн 30 хувиас илүүгүй мөнгийг Хятад дахь ар гэртээ гуйвуулах<sup>35</sup>

<sup>33</sup> МУУТА, ф-8, д-3, хн-325, 148-149-р хуудас.

<sup>34</sup> <http://www.chinanews.com/kj/shgc/news/2006/07-29/765992.shtml> 《外交档案解密:1950年代新中国对外援助逾40亿元》，来源：新民晚报；作者：杨丽琼。

<sup>35</sup> 石绍湘，“中蒙关系分析（1949-1965）”，硕士研究生论文，外交学院，2010，22页。

Ингээд хэлэлцээр байгуулсны дараа Хятад улс БНМАУ-д ажиллах хүчийг дараах байдлаар бүрдүүлэхээр шийдвэрлэжээ. Үүнд, ажилчдыг Өвөр Монгол, Жилин, Хармөрөн, Хөбэй, Жианси, Шанхай, Бээжин, Тяньжин, Сыжоу, Шаньдун, Халуун гол ба Шаньси зэрэг арван мужийн улсын өмчит хоршоолол болон улсын өмчит компаниудын үйлдвэрийн газруудаас элсүүлэх, хэрэв хангалтгүй байвал тухайн газрын орон нутгийн ажиллах хүчийг татан оролцуулах, газар тариаланчдыг Өвөр Монгол болон заасан бусад газраас дайчлахаар тогтов.

Монголд очиж ажиллах ажилчдад дараах шаардлагыг тавив. Үүнд:

1-рт, түүхийн мэдлэгтэй,

2-рт, бие чийрэг,

3-рт, 18-аас дээш настай,

4-рт, сайн дураараа санал гаргасан байх.<sup>36</sup>

Цөөн хүн амтай Монгол улс Хятадаас олон тооны ажилчин авчирч, тэдэнд амьдрах эрх олгохоор тохирсон энэ үйл явдал дэлхийн сонин, хэвлэлүүдийн анхаарлыг татаж, тухайлбал «Нью-Йорк Таймс» сонинд Хятад ажилчид Монголын талтай таван жилийн хугацаатай гэрээ байгуулж байсан бөгөөд хэрэв тэд хүсвэл Монгол улсын иргэн болох боломжтой хэмээн тухайн үед мэдээлж байв.<sup>37</sup>

Хоёр улсын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу хятад ажилчдын эхний хэсэг 1955 оны 5 дугаар сарын 8-нд ЗХУ-ын төмөр замаар дамжин Улаанбаатар хотод хүрч ирэх үед Улаанбаатарын төмөр замын буудал дээр Монголын ард иргэд хятад ажилчдыг угтан авах цуглаан зохион байгуулж угтжээ. Үүний дараа 1955 оны 5-6 дугаар сарын хугацаанд нийт 8 удаа 7,284 хятад ажилчин Монголд хүрэлцэн ирэв.<sup>38</sup>

Хятад ажилчид урьд өмнө Монголд олон мянгаараа ирж ажиллаж байсан Зөвлөлтийн мэргэжилтнүүдээс ялгаатай байв. Зөвлөлтийн мэргэжилтнүүд монголчуудад зөвлөгч, багшийн үүрэг гүйцэтгэж, соёл, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааныг заан сургаж байсан бол хятад ажилчид ажиллах хүчин ихээр дутагдаж байсан барилга, газар тариалан зэрэг салбарт мэргэжилтэй ажилчны үүрэг гүйцэтгэж байв.

1955 онд Монголд ирсэн эдгээр хятад ажилчид Монголын 100 орчим газарт 50 гаруй төрөл мэргэжлийн ажил хийж байв. Бүх ажилчдын 70 хувь буюу 5000 орчим хятад ажилчин Улаанбаатар хот ба орон нутагт барилга, бүтээн байгуулалтад ажиллаж байв. Хятад ажилчид хүрэлцэн ирснээр Монголын барилгын салбарын ажиллах хүч хоёр дахин нэмэгдэж, тэр хэрээр бүтээн байгуулалтын ажил хурдсав. 1955 онд эдгээр ажилчдын хүчээр Улаанбаатар хотод Үйлдвэрчний эвлэлийн ордон, Улсын төв музей, 60 айлын орон сууц зэрэг хэд хэдэн барилгыг барьж ашиглалтад оруулжээ.<sup>39</sup>

<sup>36</sup> 石绍湘, "中蒙关系分析 (1949-1965)", 硕士研究生论文, 外交学院, 2010, 22页。

<sup>37</sup> Raymond, J., Mongolia Imports Chinese Workers, New York Times, August 28, 1956.

<sup>38</sup> 石绍湘, "中蒙关系分析 (1949-1965)", 硕士研究生论文, 外交学院, 2010, 22页。

<sup>39</sup> Цэнд, Л., Хятадын ард түмний их тусламж – Үнэн, 1956.07.17, № 168 (6383).

1955-1960 оны хооронд Хятадаас Монголд 70 орчим мэргэжлийн нийт 15 мянга орчим хятад ажилчид, тэдний гэр бүл ирж ажиллаж, нийт 700 орчим сая төгрөгийн (үүнээс зөвхөн 1958 онд хятад ажилчид 500 сая орчим төгрөгийн ажил хийсэн) ажил хийж гүйцэтгэжээ.<sup>40</sup>

Монголд ирж ажилласан хятад ажилчид барилга, аж үйлдвэр, газар тариалан гэсэн үндсэн гурван салбарт 700 орчим сая төгрөгийн ажил хийж, тус хугацаанд Монголд олон тооны үйлдвэр, аж ахуйн газруудыг барьж байгуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн нь Монголын бүтээн байгуулалтын хурдцад зохих нөлөөг үзүүлсэн байна. Ийнхүү эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үндсэн дээр ажиллах хүчний хэлэлцээр байгуулагдаж, БНМАУ-ын эдийн засгийн хөгжилд чухал түлхэц үзүүлж байв.

### **Буцалтгүй тусламж ба хөнгөлөлттэй зээл**

1950-иад онд Монголын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй байж, үйлдвэр, зам тээвэр хөгжлийн анхны шатандаа байсан бөгөөд эдийн засгийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байв. Монголын Засгийн газар 1955 оныг хүртэл гадаад зээл, тусламжийг зөвхөн ЗХУ-аас чухал шаардлагатай салбартаа авах бодлого барьж байв. 1950-иад оны эхэн хагас хүртэлх хугацаанд Монгол улс Зөвлөлтөөс 1953, 1955, 1956 оны гурван удаагийн хэлэлцээрээр 201 сая рублийн зээл аваад байсан нь ихэвчлэн Зөвлөлттэй хийх гадаад худалдааны алдагдлыг хаах болон Зөвлөлтөөс машин, тоног төхөөрөмж худалдан авахад зориулагдаж байв.

1956 оны ЗХУКН-ын XX их хурлаас хойш Монголын гадаад зээл, тусламж авах бодлогод үндсэн өөрчлөлт гарч, Зөвлөлт, Хятад болон Зүүн Европын социалист орнуудаас зээл, тусламж авахаар хүсэлт гаргаж эхлэв. Социалист улсуудаас зээл, тусламж авах хэрэгцээ шаардлага байгаа тухай Улсын төлөвлөгөөний комиссын 1956 оны «БНМАУ-ын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газраас тусламж хүсэх тухай гаргах санал» хэмээх илтгэлд тодорхой дурджээ. Тус илтгэлд:

*“Манай орны ойрын ирээдүйн хөгжил нь байгалийн асар их баялгийг ашиглах үйлдвэрлэлийг байгуулахын хамт зам тээврийг үндсээр нь сайжруулах явдлыг шаардаж байна. Энэ зорилгыг биелүүлэхэд ихээхэн хэмжээний материал ба мөнгөн хөрөнгө ба ажилчны хүч асар ихээр шаардагдана. Манай орны соёл, эдийн засгийг түргэнээр хөгжүүлэхийг саатуулж байгаа нэг том нөхцөл бол тус орны санхүүгийн байдал ядуу байгаад оршино.” хэмээн тэмдэглээд<sup>41</sup>*

<sup>40</sup> «Үнэн», 1960.09.24, № 228 (7670).

<sup>41</sup> МУУТА, ф-11, д-2, хн-218, 128-131-р хуудас.

Тус Төлөвлөгөөний комиссоос зам тээврийн, аж үйлдвэрийн байгууламжуудын зураг төсөл гаргах, тэдгээрийг барьж ашиглалтад оруулахтай холбогдсон бүх зардал ба ажиллах хүчнээр туслах хүсэлтийг Хятадын Засгийн газарт тавих саналыг гаргажээ. Зам тээврийн ба аж үйлдвэрийн байгууламжууд гэдэгт 1500 км засмал зам, нэхмэлийн комбинат, ногоо-сүүний чиглэлийн хүнсний комбинат, биеийн тамирын ордон, загасны аж ахуй, тоосгоны үйлдвэр, модны үйлдвэр зэрэг олон тооны төслүүд багтжээ. Эдгээр төслүүд хэрэгжвэл мал аж ахуйгаас бүтсэн эдийн засагтай Монгол улс асар богино хугацааны дотор үйлдвэрлэн бүтээх хэд хэдэн үйлдвэр болон тээврийн чухал авто замтай болох байв.

Ингээд Монголын Засгийн газраас Хятадын засгийн газарт хандан хүсэлт илгээж, үүнийг үндэслэн Хятадын Засгийн газар Монгол улсад 160 сая рублийн буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэснийг Монголын Ерөнхий сайдын орлогч Л.Цэнд 1956 оны 7 дугаар сарын 17-нд «Үнэн» сониноор дамжуулан олон нийтэд мэдээлэв.<sup>42</sup>

1956 оны 8 дугаар сарын 29-нд Улаанбаатар хотноо Монгол, Хятадын хооронд «БНХАУ-аас БНМАУ-д эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээр» байгуулж, Хятадын талаас БНХАУ-ын Гадаад худалдааны яамны сайдын туслах Лу Сюй-жан, Монголын талаас БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Л.Цэнд нар гарын үсэг зуржээ. 1956 оны 8 дугаар сарын 29-ний хэлэлцээрээр БНХАУ-ын Засгийн газар 1956-1959 онуудад бүгд 160 сая хуучин рублийн буцалтгүй тусламж олгож, энэ хөрөнгөнд багтааж БНМАУ-ын Засгийн газарт үйлдвэр, хөдөө аж ахуй, зам харилцаа, соёлын газрууд болон эдгээр газруудын ажилтан ажилчдын орон сууц зэрэг 18 байгууламжийг барьж туслахаар болсон байна.<sup>43</sup>

1956 оны Хятадын буцалтгүй тусламжийн үр дүн, ач холбогдол Монгол улсад чухал үр өгөөжтэй байсан тул Монголын Засгийн газар 1958 онд Хятад улсаас ахин тусламж хүсжээ. Энэ удаагийн Монголын хүсэлт бол буцалтгүй тусламж биш, харин хөнгөлөлттэй зээл авах тухай байв. Монголын Засгийн газрын хүсэлтийг Хятадын Засгийн газар зөвшөөрөн үзэж, 1958 оны 7 дугаар сарын 29-нд БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 100 сая рублийн урт хугацааны зээлийн хэлэлцээр байгуулав. Тус зээлийг хүүгийн хамт Монголын Засгийн газар Монгол-Хятадын зохих оны худалдааны хэлэлцээрийн зарчмаар тогтоогдсон дагаж мөрдөж байгаа үнээр бараа нийлүүлэх журмаар төлж гүйцэтгэх ба жилийн нэг хувийн хүүтэй, хүүг зээлийн төлбөрийн цуг 1962 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 1976 оны 12 дугаар сарын 31-ний дотор 15 жилийн турш жил бүр тэгш хэмжээгээр төлөх нөхцөлтэй байв.

<sup>42</sup> Цэнд, Л., Хятадын ард түмний их тусламж – «Үнэн», 1956.07.17, № 168 (6383).

<sup>43</sup> МУУТА, ф-38, д-1, хн-146, 1-р хуудас.

Хятадаас Монголд 100 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгох болсон тухай Монголын «Үнэн» сонинд мэдээлэхдээ “БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид эх орондоо буцаж ирэхдээ өөрийнхөө ард түмэнд Хятадын хөдөлмөрсөг ард түмний халуун хайр баяр талархлыг авчирлаа”<sup>44</sup> хэмээн бичиж байсан бөгөөд хэлэлцээрт гарын үсэг зурсан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Моломжамц эх орондоо буцаж ирээд тус зээлийн хөрөнгийн зориулалт ба ЗХУ, БНХАУ, БНМАУ бусад социалист орнуудын ах, дүүгийн найрамдлын тухай ярилцлага өгч, Хятадын Засгийн газарт гүн талархлаа илэрхийлжээ.

Тус зээлийн хөрөнгөөр 1959-1961 онд нийт 11 байгууламж барихаар төлөвлөсний дотор Туул, Тамир, Могойтын голын төмөр бетонон гүүр, 4.5 мянган кв хүчин чадалтай цахилгаан станц, жилд 3 мянган тн мах, 1 сая өндөг үйлдвэрлэх шувууны аж ахуй, 50 мянган м2 талбай бүхий орон сууцны цогцолбор зэрэг байгууламжууд байв.

Хятадаас Монголд 1956 онд 160 сая рублийн буцалтгүй тусламж, 1958 онд 100 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгож, тус тусламжийн хөрөнгөөр хятад ажилчид Монголд олон тооны үйлдвэр, аж ахуйн газар байгуулснаар Монголын хөрөнгө оруулалт ба ажиллах хүчнээр гачигдаж байсан эдийн засагт маш чухал ашиг тус үзүүлжээ. Хятадаас Монголд үзүүлсэн тусламж нь энэ үед Зөвлөлтөөс Монголд үзүүлсэн их хэмжээний тусламжтай нийлж, Монгол улсын эдийн засгийг дан ганц хоцрогдсон мал аж ахуйгаас аж үйлдвэрийн суурь бүхий мал аж ахуйн орон болон хувирахад чухал хувь нэмэр оруулжээ.

## **Дүгнэлт**

Монгол, Хятад хоёр улс 1949 онд дипломат харилцаа тогтоож, 1952 онд гурван улсын удирдагч Москва хотод хэлэлцэн Улаанбаатар-Жининий төмөр замыг барьж байгуулахаар болсон явдал нь Монгол-Хятадын хооронд эдийн засаг, соёлын талаар өргөн хүрээнд хамтран ажиллах урьдач нөхцөлийг бүрдүүлэв.

1952 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Ю.Цэдэнбал, Жоу Эньлай нар Бээжин хотноо гарын үсэг зурсан «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-т тус хоёр улсын хооронд эдийн засаг, соёл, боловсролын талаар хамтын ажиллагааг тогтоож хөгжүүлэн бэхжүүлэх ба тус хэлэлцээрийг үндэслэн, мөн үүнийг биелүүлэх журмаар Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Бүгд Найрамдах Хятад Ард Улсын аж ахуй, худалдаа, соёл-гэгээрлийн зохих албан газруудын хооронд жич тодорхой хэлэлцээрүүд тогтоогдохоор тохиров.

<sup>44</sup> Монгол-Хятадын найрамдал хамтын ажиллагаа цэцэглэн мандаг! – «Үнэн», 1959.01.08, № 6 (7140).

Энэ хэлэлцээрийн үндсэн дээр тус хоёр улсын хооронд 1953 онд «Бараа гүйлгээ, төлбөрийн тухай хэлэлцээр» ба «Харилцан бараа нийлүүлэх гэрээ», 1955 онд «Ажиллах хүчний тухай хэлэлцээр», 1956 онд БНХАУ-ын Засгийн газраас БНМАУ-д зориулж 160 сая рублийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай, 1958 онд БНХАУ-аас 100 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгох тухай зэрэг хэлэлцээрүүд байгуулагдаж, хоёр улсын харилцаа амжилттай хөгжсөн билээ. БНМАУ, БНХАУ-ын хооронд 1960 онд «Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ» байгуулагдах хүртэл эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр нь тус хоёр улсын харилцаанд баримтлах үндсэн баримт бичиг байв.

1953 оны «Бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээр» нь эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн шууд үр дүн болсон баримт бичиг юм. 1953 оны 8 дугаар сарын 20-ны өдөр «БНМАУ-ын Засгийн газар ба БНХАУ-ын Ардын төв Засгийн газрын хооронд 1953 оны бараа гүйлгээ ба төлбөрийн тухай хэлэлцээр»-т гарын үсэг зуржээ. Хэлэлцээр 11 зүйлтэй бөгөөд 1953 онд Монголоос Хятадад 6.8 сая рубль, Хятадаас Монголд 1.3 сая рублийн бараа нийлүүлэх, худалдааны төлбөрийг хоёр улсын банкаар дамжуулах, тооцоонд рубль хэрэглэх болон бусад холбогдох асуудлыг тохирсон байна.

1953 оноос хойш Монгол, Хятад улс бусад социалист улсуудын адил харилцан бараа нийлүүлэх гэрээ байгуулж эхэлсэн нь мөн эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үндсэн дээр явагдаж байв. Худалдааны хэмжээ ч тасралтгүй өсөж, улмаар 1956 онд Улаанбаатар-Жининий төмөр зам ашиглалтад орж, үүний хамт Хятадын талаас төлөх транзит тээврийн төлбөрийг Монгол-Хятадын худалдаанд оруулж тооцох болсноор худалдааны нийт эргэлт огцом нэмэгдэв. Үүний үр дүнд 1960 он гэхэд Монголын гадаад худалдаанд Зөвлөлтийн эзлэх хувь 50-60 болон багасаж, харин Хятадын эзлэх хувь 17.8 хүрч өсжээ.

Эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үндсэн дээр ажиллах хүчний хэлэлцээр байгуулагдаж, хятад ажилчид Монголд ирж, барилга, аж үйлдвэр, газар тариалан гэсэн үндсэн гурван салбарт 700 орчим сая төгрөгийн ажил хийж, Монголд олон тооны үйлдвэр, аж ахуйн газруудыг барьж байгуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ нь БНМАУ-ын эдийн засгийн хөгжилд чухал түлхэц үзүүлжээ.

1950-иад онд Монголын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй байж, үйлдвэр, зам тээвэр хөгжлийн анхны шатандаа байсан бөгөөд эдийн засгийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байв. 1952 оны эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үндсэн дээр 1956 оны 8 дугаар сарын 29-нд Улаанбаатар хотноо Монгол, Хятадын хооронд «БНХАУ-аас БНМАУ-д эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээр» байгуулж, Хятадын талаас БНХАУ-ын Гадаад худалдааны

яамны сайдын туслах Лу Сюй-жан, Монголын талаас БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Л. Цэнд нар гарын үсэг зуржээ. Мөн үүний дараа 1958 оны 7 дугаар сарын 29-нд БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд 100 сая рублийн урт хугацааны зээлийн хэлэлцээр байгуулав. Тус зээлийн хөрөнгөөр 1959-1961 онд нийт 11 байгууламж барихаар төлөвлөжээ.

1952 оны Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр нь Монгол-Хятадын эдийн засгийн харилцаанд олон чухал үр дүн бий болох эрх зүйн суурийг тавьсан түүхэн баримт бичиг билээ.